



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 19/04

Арвайхээр сум

### Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 84 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд олон нийтийг төлөөлөх Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

2. Хяналтын зөвлөл байгуулж, энэхүү журмыг мөрдүүлж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.

3.Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтийг жил бүр аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байхыг Хяналтын зөвлөлийн ахлагчид үүрэг болгосугай.


4.Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн  
... дүгээр тогтоолын хавсралт



**ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ХЭРЭГЖИЛТЭД ОЛОН НИЙТИЙГ ТӨЛӨӨЛӨХ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН  
АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлж, мэдээлэл солилцох, үр дүнтэй, үр өгөөжтэй бүтээн байгуулалтыг амжилттай хэрэгжүүлэхэд оршино.
- 1.2. Журам нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам” болон бусад холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 1.3. Хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, сайн засаглал, нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх, олон нийтийн сайн дурын оролцоонд түшиглэх, мэдээллийн нууцлалыг хангах, улс төрийн нөлөөллөөс ангид, нээлттэй, ил тод байх зарчмыг баримтална.
- 1.4. Хяналтын зөвлөл нь төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх аливаа төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж зөвлөмж гаргах, шийдвэр гаргагчдад танилцуулан, зөрчил дутагдлыг арилгахад нөлөөлөх зорилготой ажиллана.

**ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 2.1. Хяналтын зөвлөл нь төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл, аймгийн ИТХ-ын холбогдох хорооны төлөөллөөс бүрдсэн 5 буюу түүнээс дээш сондгой тооны гишүүдтэй байна.

- 2.2. Хяналтын зөвлөлийн гишүүдийг 2 жилийн хугацаатай томилох ба улируулан томилж болно.
- 2.3. Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын захирамжаар байгуулна. Хяналтын зөвлөл нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд ажиллана.
- 2.4. Хяналтын зөвлөлийн ахлагч нь иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл байх бөгөөд байгуулагдсан гишүүдийн бүрэлдэхүүн хуралдаж, ахлагч, нарийн бичгийн даргыг дотроосоо сонгоно.
- 2.5. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй аливаа худалдан авах ажиллагааг хянахтай холбоотой нарийн мэргэшлийн мэргэжилтэн шаардлагатай бол мэргэжлийн шинжээч, зөвлөхийг томилон ажиллуулж болно.

### **ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 3.1. Хяналтын зөвлөлийн гишүүд нь хяналт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, зохион байгуулалтаас хамаарч авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллана.
- 3.2. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байх бөгөөд тухайн жилийн ажлын төлөвлөгөөний төслөө боловсруулан хэлэлцэж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд танилцуулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар төлөвлөгөөний төслийг батлуулан ажиллана.
- 3.3. Хяналтын зөвлөлийн хуралдаан нь улиралд 2-оос доошгүй удаа хуралдах бөгөөд зөвлөлийн гишүүдийн олонх ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 3.4. Хуралдааны дэгийг Хяналтын зөвлөл батлах бөгөөд хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох материалыг Хяналтын зөвлөлийн ахлагч хуралдаан эхлэхээс ажлын 3 хоногийн өмнө гишүүдэд бичгээр тараана.
- 3.5. Хяналтын зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэрт Хяналтын зөвлөлийн ахлагч гарын үсэг зурна.
- 3.6. Хяналтын зөвлөлийн шийдвэр нь зөвлөмж хэлбэрээр гарах бөгөөд зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээг олон нийтэд мэдээлнэ.

- 3.7. Хуралдааны явцыг тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд, тэмдэглэлд хуралдаанд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж холбогдох материалуудыг хавсаргана.
- 3.8. Хяналтын зөвлөл нь үйл ажиллагааны тайланг жил бүр аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлнэ.

### **ДӨРӨВ. ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй худалдан авах ажиллагааны төлөвлөлт, явц, гүйцэтгэлтэй холбоотой тайлан мэдээлэлтэй танилцах, шаардлагатай тохиолдолд хуулбар үнэн баталгаа хийлгэж, хувилж авах;
- 4.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй тендерт шалгарсан аж ахуйн нэгжийн ажлын явц, гүйцэтгэлтэй танилцах, ажлын объектод нэвтэрч, мэдээлэл цуглуулах, фото зураг авч, видео бичлэг хийх;
- 4.3. Хяналтын зөвлөлийн ахлагч нь зөвлөлийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, хуралдааныг товлон, удирдах, өөрийн эзгүйд орлон гүйцэтгэх гишүүнийг томилох, зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих эрхтэй;
- 4.4. Хяналтын зөвлөлийн гишүүд, Хяналтын зөвлөлийн ахлагчийн баталсан ажил үүргийн хуваарийн дагуу тодорхой ажил хариуцан ажиллаж, гүйцэтгэл, үр дүнгийн талаар зөвлөлийн хуралдаанд танилцуулах үүрэгтэй;
- 4.5. Хяналтын зөвлөл нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын баталсан төлөвлөгөөний дагуу ажиллаж, жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах үүрэгтэй;

### **ТАВ. САНХҮҮЖИЛТ**

- 5.1. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүр аймаг, сумын төсөвт тусгана.
- 5.2. Хяналтын зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг ажилд оролцсон байдал, ажлын үр дүнг харгалзаж олгоно.
- 5.3. Хяналтын зөвлөл нь хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардлын тодорхой хэсгийг сайн дурын үндсэн дээр хариуцаж болно.
- 5.4. Гүйцэтгэх эрх мэдлийн захиргааны байгууллага тухайн жилд хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт тусган, гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.

## ЗУРГАА. БУСАД

- 6.1. Хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллагад Хяналтын зөвлөлийн гишүүний хамаарал бүхий этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээд ажилладаг бол тухайн хяналт шалгалтад оролцох, шийдвэр гаргахаас татгалзаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу мэдэгдэл, тайлбар гаргана.
- 6.2. Хяналтын зөвлөл нь төрийн хяналт шалгалт хийх эрхгүй байх бөгөөд хяналтыг хэрэгжүүлэхдээ тухайн байгууллага, албан тушаалтны эрх хэмжээний асуудлаар шийдвэр гаргах болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцохгүй байна.
- 6.3. Энэхүү журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэнд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

----000----